

**41. Монгол-Зөвлөлтийн харилцан туслах тухай протокол (1936)**

1936 оны 3-р сарын 21-нд Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан БНМАУ, ЗХУ-ын хооронд харилцан туслах тухай протоколын 1-р зүйлд, БНМАУ буюу Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын хязгаар нутгийг гуравдугаар улсын зүгээс довтолох занал аюулууд тохиолдвол хоёр засгийн газар тохиолдсон байдлыг хамт даруй хэлэлцэж, тус хоёр улсын нутаг хязгаарыг тэрхүү занал аюулаас хамгаалах явдалд хэрэглэгдэх арга хэмжээнүүдийг авах үүргийг тус тусдаа хүлээнэ. 2-р зүйлд, энэхүү гэрээг тогтоосон нэгэн этгээдийг цэргээр довтолбол бие биедээ элдэв тусламж, мөн цэрэг зэвсгийн тусламж үзүүлэх үүрэг хүлээнэ. 2-р зүйлд, дурдсан үүргүүдийг гүйцэтгэхийн тул нөгөө этгээдийн нутагт байгаа нэгэн этгээдийн цэргийг уул үүргээ гүйцэтгэсний дараа даруй гэдрэг татах нь аяндаа гүйцэтгэх хэрэг гэж үзнэ. 4-р зүйлд, протоколыг 10 жилийн дотор хүчин төгөлдөр байна гэжээ.

БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл.

I боть, 34-35 дахь тал.

**42. БНМАУ дахь ЗХУ-ын элчин Таиравын мэдэгдэл (1938. Ш.12)**

Өнөөдөр харилцан туслах тухай протоколд гарын үсэг зурахдаа, энэхүү протоколын заалтууд нь СССР-ийн хувьд 1924 оны Зөвлөлт-Хятадын Бээжингийн хэлэлцээрт харшлах мэтээр тайлбарлаж хэрхэвч үл болох бөгөөд тэрхүү хэлэлцээр бүрэн хүчин төгөлдөрөөс гадна гадаад Монголын хил хязгаарыг аюулгүй байлгах ашиг сонирхлын үүднээс СССР улс цэргийн хүртэлх арга хэмжээ авахыг зөвшөөрсөн болохыг мэдэгдэж байна.

ГХТА. А № 0023, 19 дэх тал

**43. БНМАУ-ын ерөнхий сайд бөгөөд Гадаад явдлын яамны сайд Амарын мэдэгдэл (1986.Ш.12)**

Зөвлөлийн засагт Холбоот улс ба Хятад хоёр улсын хооронд 1924 оноо Бээжин хотод байгуулсан гэрээ бичиг болваас Зөвлөлт Холбоот Улс ба Хятад хоёр улсын хоорондох мөнхүү хоёр этгээдийн хэрэг болох бөгөөд тэрхүү гэрээ бичгийн дотор хэдийгээр Монгол улсад холбогдол бүхий зүйл буй хэмээвч энэ нь зөвхөн Холбоот ба Хятад хоёр улсын хооронд хэлэлцэн тогтоосон хэрэг бөгөөд тус БНМАУ нь хэзээ ч зөвшөөрөн хүлээж үл чадах учир шалтгааныг Зөвлөлт Холбоот Улсын Засгийн газраа удаа дараа нэвтрүүлэн мэдэгдэж байсан зүйл буй бөгөөд хэрэв хойч өдөр Хятад буюу бусад ямар нэгэн улсаас тэрхүү зүйлийг буюу түүнтэй холбогдож болох ямар нэгэн хэлэлцээ гарахад зөвшөөрч үл чадах учрыг мөн ч аль нэгэн зохих цаг тухайд нийтлэн зарлах эрхийг өөртөө үлдээн хадгалж буй учир, эл учрыг Зөвлөлийн засагт Бүгд Найрамдах Холбоот их улсын Засгийн газраа нэвтрүүлэн мэдэгдэнэ үү хэмээн илэрхийлэн хэлжээ.

ГХТА. А № 0023, 19—20 дахь тал

#### **44. Хятадын Гадаад яамны сайд Чжан Цюнийн нотоос (1936. IV.7)**

... Гадаад Монгол бол Бүгд Найрамдах Хятад улсын салшгүй хэсэг мөн учир гадаадын ямар ч улс түүнтэй ямар нэгэн хэлэлцээр байгуулж үл болно. Хятадын засгийн газрын хувьд, хүлээсэн үүргээ зөрчин Гадаад Монголтой дээрх протоколыг байгуулах Зөвлөлт Засгийн газрын ажиллагаа нь Хятадын бүрэн эрх болон 1924 оны Хятад Зөвлөлтийн гэрээний заалтыг зөрчсөн явдал даруй мөн. Иймд СССР-ийн Засгийн газраас Гадаад Монголтой дурдсан протокол байгуулсан явдал хууль бус бөгөөд Хятадын Засгийн газар тэрхүү протоколыг үл зөвшөөрөх ба ямар ч холбогдолгүйг тэмдэглэн, танай Засгийн газарт хатуу эсэргүүцэл илэрхийлж байна.

CHINA. Year Book 1936, pp. 21—22

#### **45. Хятадын хэргийг түр хамаарагчид Литвиновын өгсөн хариу нотоос (1936. IV.8)**

... Протокол байгуулсан явдал болон түүнд заасан зүйлүүд нь Хятадын бүрэн эрхийг өчүүхэн ч зөрчөөгүйгээс гадна Хятад буюу БНМАУ-ын хувьд нутаг дэвсгэрийн ямар нэгэн шаардлага тавиагүй ба агуулаагүй болно. Протокол байгуулснаар СССР ба Хятад, СССР ба БНМАУ-ын хооронд өнөө хүртэл тогтож ирсэн албан ёсны ба бодот харилцаанд ямар ч өөрчлөлт оруулаагүй болно. СССР нь харилцан туслах протокол байгуулахдаа 1924 онд Бээжинд гарын үсэг зурсан Зөвлөлт-Хятадын хэлэлцээр огтхон ч үл, хөндөгдөн хүчин төгөлдөр хэвээр байна гэдгээс үндэслэсэн юм. ЗСБНХУ-ын хувьд энэ хэлэлцээр цаашид ч хүчинтэй байна гэдгийг ташрамд зөвлөлт засгийн газар дахин нотолж байна... Үүний хамт Зөвлөлт-Монголын хэлэлцээр нь гагцхүү СССР буюу БНМАУ түрэмгийлэлд өртөж, өөрсдийн нутаг дэвсгэрийг өмгөөлөн хамгаалахад хүрэх нөхцөлд хэрэгжих учир гурав дахь орны ашиг сонирхлын эсрэг хандаагүй болно. Дээр дурдсаныг үндэслэн Зөвлөлт засгийн газар Хятадын Засгийн газрын эсэргүүцлийг үндэсгүй гэж үзэн няцаахад хүрэв.

Внешняя политика СССР (1917—1944) т. IV, с. 126

#### **46. Мао Зэдунгийн мэдэгдсэн нь (1936)**

Америкийн сурвалжлагч Эдгар Сноутай Мао Зэдун 1936 онд ярилцахдаа: Хятадад ардын хувьсгал ялсан цагт Гадаад Монгол нь өөрийн хүслээр Хятадын холбооны хэсэг аяндаа болно гэж хэлжээ.

G. M. Friters. Outer Mongolia and its international positions p. 288

#### **47. Английн Засгийн газрын байр суурь**

Британийн гадаад хэргийн туслах нарийн бичгийн дарга Гранборн 1936 онд мэдэгдэхдээ, эрхэмсэг Засгийн газар нь Гадаад Монголд Хятадын сюзеренитетийг зөвшөөрснөөсөө хэзээ ч няцаж байгаагүй гэжээ.

G. M. Friters, Outer Mongolia and its international positions p. 271

#### **48. Риббентропын мэдэгдэл (1940)**

Германы Гадаад яамны сайд Риббентроп 1940 оны 11-р сард ЗХУ ба Японы хооронд зуучлах саналт тавихдаа тэдгээр улсын хооронд «үл довтлолцох гэрээ байгуулах аваас Япон нь Гадаад Монгол ба Синь Зянд Оросын нөлөөний хүрээг Хятадтай ойлголцсон нөхцөлд зөвшөөрөх хүсэлтэйг мэдэж байсан» гэж хэлжээ.

#### **49. Зөвлөлт-Японы тунхаглалаас (1941.IV.13)**

СССР ба Япон улсуудын хооронд төвийг сахих тухай байгуулсан гэрээ хэлэлцээний амьсгалд тохируулан СССР-ийн Засгийн газар ба Японы Засгийн газраас тус хоёр орны хооронд эв найрамдлын тайван харилцааг хангахын тулд ёслон зарлах нь:

СССР нь Манж-го-гийн дэвсгэр нутгийн бүрэн бүтэн бөгөөд халдашгүй дархан байдлыг хүндэтгэх үүргийг хүлээнэ.

Япон нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дэвсгэр нутгийн бүрэн бүтэн бөгөөд халдашгүй дархан байдлыг хүндэтгэх үүргийг хүлээнэ

БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл, I боть, 278 дахь тал.

#### **50. Хятадын Гадаад яамны эсэргүүцэл (1941.IV)**

Хятадын Гадаад яамны сайд Ван Жунхигийн 1941 оны 4-р сарын 14-ний албан ёсны эсэргүүцэлд:

Умард дөрвөн муж ба Гадаад Монгол (Манж-го ба БНМАУ хэмээгдэгч) нь БН Хятад улсын салшгүй хэсэг бөгөөд хэзээд Хятадын нутаг хэвээр байх нь маргашгүй. Иймд Хятадын Засгийн газар ба ард түмэн гурав дахь этгээдийн зүгээс Хятадын газар нутгийн ба засат захиргааны бүрэн бүтэн байдлыг зөрчин ямар нэг үүрэг хүлээснийг зөвшөөрч үл чадах учир Зөвлөлт-Японы тунхаглалыг Хятадад ямар ч холбогдох хүчингүй гэж үзэж байна гэжээ.

G. M. Friters. Outer Mongolia and its international positions p. 207

#### **51. Монголын талаарх Зөвлөлтийн бодлогыг О. Латтимор хэрхэн үзэж байсан**

**нь**

Зөвлөлт Орос нь Гадаад Монголтой эвслийн гэрээ байгуулсан боловч Монголын тусгаар тогтнолыг Хятадаар зөвшөөрүүлэх гэж хэзээ ч хүчилж байгаагүй, харин Монголд Хятад суверенитет эрхтэйг зөвшөөрсөн билээ. Иймд Зөвлөлтийн бодлого нь өөрсдийгөө тусгаар тогтносонд тооцдог монголчууд хэмээх ард түмэнтэй хил залгадаг, энэ оронтой тогтоосон нөхөрсөг харилцаа нь Японы түрэмгийлэлд нэрвэгдэж болох Сибирийн жигүүрийг олон жилийн турш хааж байгаа гэдгээр тодорхойлогдож болох юм. Гадаад Монголд Хятадын цэрэг буюу Хятадын Засгийн газрын төлөөлөгчид байхгүй. Оросууд, өөрийн орон бүхий ард түмэнтэй харилцдаг, тэгэхдээ Монголын тусгаар тогтнолыг Хятадаар зөвшөөрүүлэх юм уу, тэгэх тусмаа монголчуудад Хятадын захиргааг хүлээлгэх гэж хүчлэхийг өөрийн хэрэг гэж үзээгүй юм.

O. Lattimore. Solution in Asia, Boston. 1945, p. 143

#### **52. Ф. Рузвельтэд А. Гарриманы явуулсан илгээлт (1944)**

Москва дахь элчин сайд Гарриманаас ерөнхийлөгчдөө:

Урьд шөнө би Сталинтай ярилцахдаа 10 дугаар сард түүний дурдаж байсан улс төрийн ямар асуудлуудыг Орос улс Японы эсрэг дайнд орохтой холбогдуулан тавих тухайн Таны зүгээс мэдэхийг чухалчлан хүсэж байгааг хэлсэн юм.

Тэрээр, Тегеранд дурдаагүй ганц зүйл бол Гадаад Монголын Бүгд Найрамдах Улсыг тусгаар тогтносон этгээд хэмээн үзэж Гадаад Монголын status quo-г хүлээн зөвшөөрөх явдал юм гэж хэлэв. Энэ нь надад гайхмаар зүйл биш байв, учир нь Сибирийн өмнөд урт хилийг хамгаалах эрмэлзлийн үүднээс Зөвлөлтийн байр суурь ийм байх болно гэдэгт

би олон сарын ажиглалтаас итгэсэн юм гэж 12 дугаар сарын 15-нд мэдээлжээ.

Foreign Relations of the US. Dip. papers.

The conference at Malta and Ualta 1945, Washington, 1955. p. 379

### **53. Ф. Рузвельт зөвлөхүүдтэйгээ ярилцсан тэмдэглэлээс**

1945 оны 2 дугаар сарын 4-нд зөвлөхүүдтэйгээ Рузвельтийг уулзахад Гарриманаас Гадаад Монголын status quo-г хэвээр хадгалах асуудлыг Сталин тавьж магадгүй гэхэд ерөнхийлөгч: Гадаад Монголын status quo-г хэлэлцэхээс өмнө генералиссимус Чан Кайшийн санал авахыг хүсэх бөгөөд харин бусад асуудлыг урагшлуулахад бэлэн байна гэж хэлжээ.

Foreign Relations of the US. Dip. papers.

The conference at Malta and Ualta 1945, Washington, 1955, p. 567

### **54. Гурван гүрний Крымын хэлэлцээрээс (1945. П.11)**

Гурван их гүрэн-Зөвлөлт Холбоот Улс, Америкийн Нэгдсэн Улс, Их Британи Улсын удирдагчид Европт дайн дууссанаас хойш хоёр гурван сар өнгөрмөгц холбоотнуудын талд Японы эсрэг Зөвлөлт Холбоот Улс дор дурдсах нөхцөл болзлыг хангавал дайнд орох тухай харилцан тохиролцов. Үүнд:

1. Гадаад Монголын (Бүгд Найрамдах Монгол Ард Улсын) статус-квог (оршин тогтнож байгаа байдлыг) хэвээр хадгалах. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл, I боть, 278-279 дэх тал

### **55. И. В. Сталин, Сун Зывэнийн хэлэлцээний тэмдэглэлээс**

Москвад 1945 оны 7-р сард болсон Зөвлөлт-Хятадын хэлэлцээний явдалд:

Сталин: -Зарим улс Гадаад Монголоор түшиц хийж, ЗСБНХУ-ын Алс Дорнод дахь байр суурийг алдагдуулахыг оролдож байна. Хэрэв ЗСБНХУ Гадаад Монгол шиг бамбай улсгүй байх юм бол Алс Дорнодын нутаг дэвсгэрээ хамгаалж чадахгүй. Японыг буулгалаа ч гэсэн 5—10 жилийн дараа дахин, өндийн босож ирнэ. Гадаад Монголын ард түмэн Дундад улстай нэгдэх дургүй, ЗСБНХУ-тай ч нэгдэх дургүй. Иймээс тусгаар тогтновол зохино. Тэр ч байтугай Гадаад Монголын зарим хүн Өвөр Монголыг турхирч, нэгдмэл нэгэн Их Монгол улс байгуулах гэж байна. Хэрэв ийм байдал үүсвэл Хойд Хятадад аюул учирна. Иймээс Дундад улсын ашиг тусын үүднээс бодвол Гадаад Монголыг тусгаар тогтноулах нь бүр ч ашигтай болох юм.

Сун Зывэнь — Дундад улсын Засгийн газар хэрхэвч нутаг дэвсгэрээ хаяхгүй. Эс тэгвэл ард түмэндээ итгэл алдана. Дундад улсын Засгийн газар Дундад улсын ард түмэнд Гадаад Монголыг оролцуулан нутаг дэвсгэрээ бүрэн бүтэн байлгах баталгаа гаргаж ирсэн Ялтын хэлэлцээрт зөвхөн Гадаад Монголын одоогийн байдлыг хадгална гэснээс биш Гадаад Монголыг тусгаар тогтноулна гэж заагаагүй.

Сталин —Гадаад Монголын одоогийн байдал гэдэг нь тусгаар тогтнолыг хэлж байгаа юм.

Дундад, Зөвлөлтийн найрамдал, холбооны тухай 1945 оны гэрээний талаар хийсэн хэлэлцээний далд учир (Л. Жамсрангийн орчуулга БНМАУ-ын тусгаар тогтнолыг хэлэлцэн тохиролцсон нь). Дорно дахины судлалын асуудал. 1989, № 2 (21) 21—23 дахь тал.

**56. Монголын талаар АНУ-ын баримталбал зохих байр суурийг О. Латтимор илэрхийлсэн нь (1945)**

Бидэнд Гадаад Монголыг Хятадын дэвсгэр нутаг гэдэг Хятадын шаардлага болон Гадаад Монголыг тусгаар тогтносон гэж үзэх Оросын бодлогын аль алиныг дуурайсан санаачилга гаргахын хэрэгцээгүй. Гадаад Монгол хэрэг дээрээ олон жил тусгаар тогтнож ирсэн бөгөөд дайны төгсгөлд хятадууд Монголчуудыг хүчээр дагуулах байр суурь, эзлэх ёсгүй гэдэг нь бидэнд чухал юм.

Монголын талаарх эсрэг тэсрэг шаардлага, Хятад ба Орос улстай бидний тогтоосон нөхөрсөг харилцаанд сэв учруулбал манай сонирхолд үл нийцнэ. Иймд, хятадууд ба монголчууд чөлөөт ард түмний ёсоор харилцах нь бидний сонирхлын хэрэг бөгөөд Монголын тусгаар тогтнолыг Хятад хүлээх юм уу, Хятадын холбоонд Монгол чөлөөтэй орохыг зөвшөөрөх замаар уу гэдэг нь төдий л хамаатай бус. Яаж ч шийдлээ гэсэн бид Монголтой дипломат харилцаа тогтоож, тэнд эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулбал зохино.

O. Lattimore. Solution in Asia. P. 177—178

**57. Хятад ба ЗХУ-ын Гадаад яамны сайд нарын солилцсон нот бичгүүдээс (1945.V.14)**

Хятадын хотонд: Гадаад Монголын ард түмэн тусгаар тогтнохыг удаа дараа хүсэж эрмэлзсэн учир дундад улсын Засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг зөвшөөрнө. Дээр дурдсан илэрхийлэл нь Дундад Иргэн Улс, СССР хоёрын хооронд 1945 оны 8-р сарын 14-нд байгуулсан холбоо, найрамдлын тухай гэрээг баталмагц заавал хүчин төгөлдөр болно.

Зөвлөлтийн нотонд: Зөвлөлт засгийн газар, Дундад Иргэн улсын Засгийн газрын дээр тодорхойлсон нот бичгийг сэтгэл ханамжтай хүлээн авч өөрийн зүгээс илэрхийлэх нь: тус Зөвлөлт засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улс (Гадаад Монгол)-ын төрийн тусгаар тогтнол ба нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэн үзнэ.

БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгийн эмхтгэл, I боть. 279—280 дахь тал.

**58. Чан Кайшигийн мэдэгдлээс - (1945. VI.24)**

Хятадын үндэсний батлан хамгаалах дээд зөвлөл ба Гоминданы төвийн гүйцэтгэх хорооны хамтарсан хурал дээр Чан Кайши:

... Гадаад Монгол нутгийн хүмүүс аль 1922 онд Бээжингийн засаг тогтож байх үед эх улсаасаа тусгаарласныг тунхагласнаас хойш бараг хорин таван жил өнгөрчээ. Ийм учраас бид манай хувьсгалт зарчим болон Гоминданы байнгын бодлогод нийцүүлэн Гадаад Монголын тусгаар тогтнолыг эрс шийдэмгий бөгөөд хуулийн дагуу хүлээн зөвшөөрч, найрамдалт харилцаа тогтоох ёстой гэж хэлжээ.

The Collected war-time Messages of Generalissimo Chiang.

Vol. 11. N. U, 1949, pp 855—856.

**59. Москва дахь Америкийн ЭСЯ-аас Төрийн департаментад явуулсан илгээлтээс (1945. IX)**

Монголын тусгаар тогтнолыг Хятадаас хүлээн зөвшөөрөх асуудалтай холбогдуулан АНУ-ын Төрийн департаментад Москва дахь ЭСЯ наас мэдээлэхдээ:

Гадаад Монголыг хүлээн зөвшөөрснөөс түүний дотоод дэглэмд ямар ч өөрчлөлт гарахгүй, харин ирээдүйд Хятадтай нийлүүлэх боломжийг

үгүй хийх юм. Цаашилбал энэ нь зэргэлдээ газар нутгуудыг Зөвлөлтийн нөлөөнд оруулахад ашигтай дэвсгэр болгож мэдэх юм гэжээ.

Robert A. Rupen. Noies on Outer Mongolia, «Pacific Affairs».  
Vol. XXVP. № 1, 1955, pp. 71-72

#### **60. Монголын ард түмний санал хураалтын дүн (1945)**

БНМАУ-ын тусгаар тогтнолын асуудлаар нийтийн санал гаргуулсан дүнгийн тухай Төв комиссын тогтоолд: .

БНМАУ-ын төрийн тусгаар тогтнолын төлөө 487409 хүн саналаа өгсөн буюу санал гаргахад оролцсон бүх ард иргэний 100 хувь болжээ. Санал гаргуулах ажил бол БНМАУ-ын ард түмний төрийнхөө тусгаар тогтносны төлөө эрмэлзлийг бүрэн баталсан тул энэхүү тусгаар тогтнолыг 1945 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Дундад Иргэн Улсын Засгийн газраас илэрхийлсэн ёсоор Дундад Иргэн Улс нь зөвшөөрөн хүлээх ёстой болно гэжээ.

«Үнэн». 1945 оны 11 дүгээр сарын 15. № 160

#### **61. Хятадын Засгийн газрын албан мэдээнээс (1946.1.5)**

... Ард нийтийн санал хураах процедурыг удирдсан Гадаад Монголын эрх баригчдаас саяхан ирүүлсэн илтгэлд үзвэл, ард нийтийн саналын дүн нь Гадаад Монголын ард түмэн тусгаар тогтносон байдлын төлөө саналаа өгснийг батлав.

Үндэсний засгийн газар, үндэсний батлан хамгаалах дээд зөвлөлийн шийдвэрт нийцүүлэн Гадаад Монголын тусгаар тогтносон байдлыг зөвшөөрөн хүлээгээд, гүйцэтгэх Юанаас энэ тухай Гадаад Монголын Засгийн газарт албан ёсоор мэдэгдэх зааврыг Дотоод явдлын яаманд өгөв гэжээ.

БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгийн эмхтгэл. I боть. 280 дах. Тал

(Үргэлжлэл бий)

Уг хураангуйг эмхлэн  
хэвлэлд бэлтгэсэн  
академич Б. Лхамсүрэн